**МОНГОЛ УЛСЫН**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ**
**САЙДЫН ТУШААЛ**

2006 оны 11 сарын 27 өдөр Дугаар 421 Улаанбаатар хот

## Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэмчигжав овогтой Чимэддоржийг АНУ-ын Стрэйер их сургуулийн магистрантурт мэдээллийн системийн удирдлагын чиглэлээр Түлш, эрчим хүчний яамны захиалгын дагуу, ~~Нанжаа овогтой Цогзолмааг Австрали улсын Күртин технологийн их сургуулийн магистрантурт эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр Эрүүл мэндийн яамны захиалгын дагуу~~ тус тус 2006-2007 оны хичээлийн жилээс 2 жилийн хугацаагаар Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

САЙД Ө.ЭНХТҮВШИН